

Мэргэжлийн ур чадвар дээшлүүлэгч нарт

Оны төгсгөлийн 12-р сар болж, хүйтний эрч чангарч эхэллээ.

Мэргэжил дээшлүүлэгч та бүхэн сайн сууцгааж байна уу.

Шинэ төрлийн корона вирус халдвар тархаж байгаа тул түүний эсрэг арга хэмжээ авч, урьдчилан сэргийлж, эрүүл мэнддээ сайн анхаарч, шинэ оноо эрүүл чийрэг сайхан угтаарай.

Мөн урт амралтын үед байрныхаа цахилгааныг хэрэггүй зүйлд үрэлгэн зарцуулах тохиолдлууд байдаг. Иймээс эрчим хүчээ хэмнэх тал дээр анхаарч, халаалтын төхөөрөмжөө асаалттай хэвээр нь гадагш гарч болохгүйг анхаараарай.

Оны төгсгөл болон эхэн үеийн амралтын хугацаанд анхаарах зүйлийг доор бичсэн байгаа учир сайн уншиж, дүрэм журмаа баримтлаарай.

1. Шинэ төрлийн корона вирус халдвараас урьдчилан сэргийлэх талаар

- Маск зүүх, амны хаалт хэрэглээгүй хүмүүстэй ярихаас зайлсхийх
- Хүмүүсийн хооронд 1 м ба түүнээс дээш зайтай байж, аюулгүй байдлаа хангах
- Олон тооны хүмүүс эсвэл удаан хугацаагаар идэж, уухаас зайлсхийх
- Хэрэглэхгүй байгаа өрөөний цонхоо өргөн онгойлгох гэх мэтчилэн хүйтэн орчинд ч гэсэн агааржуулах хэрэгтэй
- https://www.otit.go.jp/CoV2_jisshu_kansen/ -ээр орж шалгана уу.

2. Өвчний тухай

Ханиад томуу, шинэ төрлийн болон улирлын шинжтэй ханиад томуунаас урьдчилан сэргийлэх.

- Гаднаас орж ирсэн үедээ болон, хоол идэх үедээ заавал гараа савангаар угааж, хоолойгоо зайлаарай.
- Дүрэм журмын дагуу зөв амьдарцгаая. (Шөнө оройтож унтахгүй байх)
- Тэжээллэг хүний биед ашиг тустай балансаа барьсан хоол идэх тал дээр анхаараарай.

3. Зам тээврийн ослын тухай.

Япон улсын замын хөдөлгөөний дүрмийг чандлан баримталж, зам тээврийн осолд орохгүй байхын тулд анхаарал болгоомжтой байцгаая.

Хэрвээ ямар нэг осол болвол ...

Холбоо барих карт болон түр оршин суух картаа үргэлж биедээ авч явж, төсөөлж байгаагүй нөхцөлд байдалд орсон ч гэсэн тайвширч байгаад нийгэмлэг болон хариуцсан төлөөлөгчтэй заавал холбоо бариарай.

Мөн унадаг дугуйны замын хөдөлгөөний дүрмийг сайн баримтлаарай. Замын хөдөлгөөний дүрмийг сайн баримтлана гэдэг нь =Өөрийн биеийг хамгаална гэсэн үг.

4. Цагийн ажлын тухай.

Мэргэжил дээшлүүлэгч хүн цагийн ажил болон давхар ажил хийх хориотой байдаг . !

Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн 1 дэхь жил нь “ Мэргэжил дээшлүүлэх 1 хөтөлбөр ”

2,3 дахь жил нь “Мэргэжил дээшлүүлэх 2 хөтөлбөр” юм.

Өөр аж ахуй нэгж, өөр газраас цалин хөлс авах нь өөр ажил хөдөлмөр эрхэлсэнд тооцогдох учир тухайн хүн болон компани нийгэмлэг ч гэсэн шийтгэл хүлээх болно. Мөн мэргэжил дээшлүүлэгч нь хууль бус үйл ажиллагаа хийсэнд тооцогдож нутаг буцаах хүртэл арга хэмжээ авна.

5. Газар хөдлөлтийн тухай.

Япон улс газар хөдлөлт ихтэй улс гэгддэг. Хэрвээ газар хөдлөлт болвол, юу хийх, ямар арга хэмжээ авах вэ, та бүхэн мэдэж байгаа юу. Мөн өөрийгөө хамгаалах үйл хөдөлгөөн хийж чадахуу. Газар хөдлөлттэй холбоотой материал (ахуй амьдралын заавар зөвлөгөөний сурах бичиг болон галын хэрэг эрхлэх газрын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага (https://www.fdma.go.jp/relocation/bousai_manual/index.htmlзэрэг)-ыг үзэж, зөв мэдлэгтэй болцгооё.

6. Бусад зүйл

Компани дүрэм, дотуур байрны дүрэм журам, Япон улсын хууль дүрмийг заавал мөрдөцгөө. Гэмт хэрэг үйлдсэн л бол Япон хүн, гадаад хүн нь хамаагүй ял шийтгэл хүлээх болно. Гэмт хэрэгтний нэр шошго бол нэг удаа л хадагдвал яаж ч байсан хуулагдахгүй зүйл шүү.

- Хий дэмий гадуур хонохыг хориглоно. Компани нийгэмлэгийн дүрмийг баримталж зөвшөөрөл авцгаая.

(Зөвшөөрөл өгөхгүй тохиолдол ч байна. Заавар зөвлөгөөгөө дагацгаая.)

Та бүхнийг Япон улсад байх хугацаанд аюулгүй амар амгалан байлгах үүднээс гаргасан дүрэм журам юм шүү. ! Нэг удаагийн наргиан цэнгэлээсээ болж өөрийн хувь тавилан амьдралаа үрэн таран хийх үйлдлийг гаргахгүйн тулд заавал дүрэм журмаа баримталъя.

Хулгай хийх, галт тэргэнд туулайчлах, гадаанаас олсон дугуй унах нь гэмт хэрэг юм шүү. ! Зөвшөөрөгдөхгүй !.

Харамсалтай хэдий ч гадаадын гэмт хэргийн бүлэглэлүүд мэргэжил дээшлүүлэгч нарыг гэмт хэргийн байгаа болгож , гэмт хэрэгт уруу татах явдал ихсэж байна. Нэг нутгийн чинь хүн байсан ч гэсэн амар хялбар яриа, урилганд нь уруу татагдаж болохгүй. Амар хялбар яриа урилганы цаана унах нүх байгаа шүү. Өөрөө, өөрийнхөө амь насыг хамгаалаарай.

Гадаад паспорт, түр оршин суух үнэмлэхээ Нийгэмлэг , компаниас өөр газар огтхон ч өгч болохгүй. Цагаачлалын албанаас шууд хурааж авахгүй . Чиний гадаад паспорт, түр оршин суух үнэмлэхийг буруу зүйлд ашиглах гээд анаж байна. Анхаарал болгоомжтой байгаарай. !